

Article

A review of scholarly perspectives on emotional intelligence

Batchuluun Purev^{1,2*}, Pagmadulam Sarantuya², Tuul Mytav³, Khishig-Undrakh Mijgee⁴

^{1,4} Department of Psychology, School of Education, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

^{2,3} Department of Medicine, School of Medicine, Etugen University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: batchuluunpurev935@gmail.com



<https://orcid.org/0009-0003-1994-4853>

Received: 01 November 2025

Accepted: 12 December 2025

Published online: 31 December 2025

Abstract

Emotional Intelligence is a person's ability to cognitively construe and regulate her or another's emotions. This term was coined by Salovey and Mayer (1990). EI constitutes an important factor in determining an individual's psychological well-being, academic success, job performance and leadership abilities. Further studies have indicated that emotional intelligence has a powerful and distinct effect in various aspects of life. Goleman (1995) showed that EI surpasses IQ in predicting personal and professional success. Cherniss (2010) reported that people with high EI are more productive and team friendly. Several models have been developed to measure EI. Bar-On (2006) developed a test for EQ-i and identified nine factors of EI. Mayer, Caruso, and Salovey (2016) developed the Ability Model that includes emotion perception, emotion understanding, and emotion regulation. A few studies have been conducted in Mongolia about the cultural and behavioral perspective of EI. For example, D. Enkhjargal (2018) examined the development of EI drawing on Mongolian traditional values and personality traits. B. Batsaikhan (2020) reported that the cultivation of EI in teaching and learning improves students' creativity and their communication and leadership skills. In the study conducted by researchers B. Enkhbayar and P. Tserendondov, emotional intelligence (EI) is examined as an independent psychological construct, interpreted from multiple perspectives such as a component of intelligence, a combination of non-cognitive abilities, and a domain of social intelligence.

Keywords: Emotional Intelligence, Education, EQ, EQ-i, EI



© 2025, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator.

<https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны тухай эрдэмтдийн үзэл баримтлал тойм судалгаа

Пүрэвийн Батчулуун^{1,2}, Сарантуяагийн Пагмадулам², Мятавын Туул³, Минжээн Хишиг-Ундрах⁴

^{1,4} Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Сэтгэл судлал арга зүйн тэнхим, Улаанбаатар хот, Монгол улс

^{2,3} Этүгэн Их Сургууль, Анагаах ухааны тэнхим, Улаанбаатар хот, Монгол улс

Хураангуй

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүн өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг танин мэдэх, ухамсарлах, зохицуулан удирдах танин мэдэхүйн чадварын нэгдсэн бүрдэл юм. Энэхүү ойлголтыг анх Salovey ба Mayer (1990) нар тодорхойлсон бөгөөд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүний сэтгэлзүйн сайн сайхан байдал, сурлагын амжилт, ажлын гүйцэтгэл, манлайллын чадавх зэрэг олон талт үзүүлэлтэд шууд нөлөөлөх хүчин зүйл болохыг тодорхойлсон байдаг. Дараах судалгаануудын үр дүнгээр EQ нь IQ-аас илүү амжилтыг таамаглах боломжтой болохыг Goleman (1995), өндөр EQ-тэй ажиллах хүчин бүтээмж болон хамтын ажиллагааны хувьд давуу байгааг Cherniss (2010) тус тус нотолсон нь энэхүү үзэл баримтлалыг улам гүнзгийрүүлсэн.

СХОУ-ыг тодорхойлох, үнэлэх хэд хэдэн загвар боловсруулагдсан бөгөөд Bar-On (2006) EQ-i тестийг бий болгон есөн бүрэлдэхүүн хэсгийг, харин Mayer, Caruso, Salovey (2016) нар мэдрэх-ойлгох-удирдах гэсэн чадварт суурилсан загварыг хөгжүүлсэн нь онолын хүрээг тэлсэн. Монголд СХОУ-ны талаар хийгдсэн судалгаа харьцангуй цөөн бөгөөд үндэсний соёл, зан төлөвийн онцлогийг багтаасан судалгааны хэрэгцээ байсаар байна. Үүний хүрээнд Д. Энхжаргал (2018) уламжлалт үнэт зүйл болон зан төлөвт тулгуурласан СХОУ-ны хөгжилд дүн шинжилгээ хийсэн бол Б. Батсайхан (2020) боловсрол дахь EQ хөгжүүлэлт нь сурагчдын бүтээлч сэтгэлгээ, харилцаа, манлайллын чадварыг дээшлүүлэх ач холбогдолтойг тогтоосон. Судлаач Б.Энхбаяр, П. Цэрэндондов нарын судалгаанд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан (СХОУ) нь бие даасан сэтгэцийн үзэгдэл болох онолыг судалж оюун ухааны бүрэлдэхүүн хэсэг, танин мэдэхүйн бус чадваруудын нэгдэл, нийгмийн оюун ухааны нэг тал гэх мэт олон талаас тайлбарласан.

Түлхүүр үгс: Сэтгэл хөдлөлийн оюун ухаан, Боловсрол, EQ, EQ-i, EI

Оршил

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүн сэтгэл хөдлөлөө танин мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах, бусад хүмүүсийн сэтгэл хөдлөлийг ойлгож харилцаандаа ашиглах чадвар юм (Salovey & Mayer, 1990). Энэхүү судалгаагаар бид сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны тухай олон улсын болон дотоодын эрдэмтдийн үзэл баримтлалыг нэгтгэн дүгнэхэд оршиж байна. Судалгаагаар өндөр EQ (сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан) бүхий хүмүүс харилцааны ур чадвар сайтай, багийн ажиллагаанд илүү сайн зохицдог, ажлын бүтээмж өндөртэй, удирдах чадвартай байдаг нь тогтоогдсон (Cherniss, 2010). Brackett, Rivers, & Salovey нарын 2011 онд хийгдсэн судалгаагаар, **сэтгэл хөдлөлийн оюун ухааны** хамгийн чухал нь хүн өөрийн дотоод сэтгэл хөдлөлийн мэдрэмжийг танин мэдэх, харилцаандаа сэтгэл хөдлөлөө удирдах, зохицох чадвар юм. Өгүүлэлд дурдсан **сэтгэл хөдлөлийн боловсрол** болон **сэтгэл хөдлөлийн удирдлагын стратегиуд** нь хувь хүний хувьд ч, нийгмийн хувьд ч боловсрол, ажил эрхлэлт, амьдралын чанарт эерэг үр дагавартай юм. Орчин үеийн нийгэмд хүн хоорондын харилцаа улам бүр төвөгтэй болж байна. Ийм нөхцөлд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хүмүүсийн

харилцааны ур чадварыг сайжруулж, амжилттай ажиллах, эерэг уур амьсгал бүрдүүлэх гол хүчин зүйл болдог. Монгол эрдэмтдийн судалгаанд СХОУ-ны талаар олон сонирхолтой үр дүн гарсан байдаг. 2018 онд хийгдсэн эрдэмтэн Д. Энхжаргал нарын судалгаанд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг монгол хүний зан төлөв, уламжлалт соёл, гэр бүлийн харилцаатай холбон тайлбарлаж, энэ нь харилцааны хэв маягт чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тогтоосон байна.

Судалгааны арга зүй: Судалгаанд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаарх олон улсын болон дотоодын судлаачдын онолын үзэл баримтлал, тодорхойлолт, загваруудыг системтэйгээр нэгтгэх системчилсэн тойм судалгааны арга зүй ашигласан. Судалгаанд 1990–2024 оны хооронд хэвлэгдсэн 30 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, диссертаци, мета-анализ ба онолын бүтээлүүдийг сонгон судалж тэдгээрийг агуулгын ангиллын дагуу кодлон шинжлэв. Өгүүллийн сонгон шалгаруулалт дараах шалгуураар хийгдсэн. Үүнд: Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны онол, загвар, хэмжилтийн талаар өгүүлсэн байх, Туршилт, сорил, шалгалтын арга болон хэмжилзүйн баталгаажуулалттай байх, Монголын соёлын онцлог, боловсрол, байгууллагын удирдлага, хүний нөөцтэй холбосон судалгааг оруулсан. Өгөгдлийн хайлт хийхдээ Emotional Intelligence, Stress Management, Leadership, EQ-i, TEI-SF, Social emotional competence зэрэг түлхүүр үгсийг ашиглаж олон улсын сангууд болон монголын академик эх сурвалцаас мэдээлэл авсан. Сонгогдсон бүтээлүүдийг харьцуулан шинжлэх, ангилах, дахин давтагдал ба нийтлэг гаргалгааг тодруулах байдлаар боловсруулж, онолын үндэслэл болон судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэсэн.

Судалгааны шинэлэг тал

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзэл баримтлалыг олон улсын болон Монголын эрдэмтэн судлаач нарын судалгааны үр дүнгүүдийг судалсан нь шинэлэг тал болно.

Судалгааны үр дүн

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүний сэтгэл хөдлөлийг танин мэдэх, удирдах, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар юм (Salovey & Mayer, 1990). Энэхүү ойлголт нь сэтгэл судлал, боловсрол, удирдлага-манлайлал, эрүүл мэнд, хүний хөгжлийн олон чиглэлд чухал байр суурь эзэлдэг бөгөөд Goleman сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хувь хүний болон мэргэжлийн амжилтад нөлөөлөх чухал хүчин зүйл гэж үзсэн байдаг. СХОУ-ны талаар олон улсын болон монгол эрдэмтэд судалгаа хийж, өөр өөрийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн бөгөөд тэдгээрийн дүгнэлтүүд нь уг ойлголтын ач холбогдлыг улам тодотгож байна (Bar-On, 2006).

Б. Батсайхан 2020 онд хийсэн судалгаагаар боловсролын салбарт СХОУ-ны ач холбогдлыг судалж, сурагчдын харилцааны ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, стрессийн даван туулах чадварыг хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй болохыг дурдсан. Мөн О. Гантулга 2019 онд байгууллагын удирдлагын хүрээнд СХОУ-ны үүргийг судалж, удирдагчийн EQ өндөр байх нь хамт олны уур амьсгалыг сайжруулж, байгууллагын үр ашгийг нэмэгдүүлдэг болохыг тогтоосон.


Израилийн сэтгэл судлаач Reuven Bar-On сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг үнэлэх EQ-I загвараа 1997 онд боловсруулсан. Дараах загварт сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны есөн үндсэн бүрдэл хэсгийг тодорхойлсон байна. Үүнд: Өөрийгөө үнэлэх -Self-Regard, сэтгэл хөдлөлөө ойлгох -Emotional Self-Awareness, Өөрийн мэдрэмжийг илэрхийлэх чадвар - Assertiveness, өөрийгөө хянах - Impulse Control, уян хатан байх чадвар - Flexibility, стрессийг даван туулах чадвар - Stress Tolerance, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар – Empathy, хүмүүс хоорондын харилцааг ойлгох чадвар - Interpersonal Relationships, амьдралдаа сэтгэл хангалуун, эерэг байх чадвар – Happiness.

Cherniss 2010 онд хийгдсэн судалгаанд сэтгэл хөдлөлийн оюун ухааны тодорхойлолт, түүнд суурилсан хэрэглээ нь байгууллагын амжилт, ажилчдын гүйцэтгэл болон харилцааны чадавхийг сайжруулахад хэрхэн нөлөөлдгийг тодруулж, энэ ойлголтыг илүү өргөн хүрээнд ашиглах боломжийг нээжээ. Түүний судалгаа нь **сэтгэл хөдлөлийн оюун ухааны** олон талт хэрэглээ болон хүний зан төлөв, сэтгэл хөдлөлийн удирдлага, ажил дээрх харилцаа зэрэг цогц чадварууд хэмээн үзсэн.

Даниэл Гоулманы (1995) *"Emotional Intelligence: Why It Can Matter More Than IQ"* номонд сэтгэл хөдлөлийн оюун ухаан (EQ) нь хувь хүний амжилт, харилцаа, ажлын бүтээмжид чухал нөлөө үзүүлдэг болохыг онцолсон. Тэрбээр зөвхөн IQ өндөр байх нь амжилтын гол түлхүүр биш бөгөөд хүмүүсийн сэтгэл хөдлөлийн зохицуулалт, өөрийгөө ойлгох, бусадтай үр дүнтэй харилцах чадвар нь илүү чухал болохыг судалгаагаараа баталсан. Даниэл Гоулманы судалгаагаар сэтгэл хөдлөлийн оюун ухаан дараах таван үндсэн хэсгээс бүрддэг.

1. Өөрийгөө танин мэдэхүй - Self-awareness Хувь хүн өөрийнхөө сэтгэл хөдлөл, давуу болон сул талуудыг ойлгох чадвар юм. Өөрийн зан байдал, үйлдэл хэрхэн бусдад нөлөөлж байгааг ухамсарлах нь нэн чухал юм. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны өндөр чадвартай хүмүүс өөрийн мэдрэмжээ илүү тодорхой ойлгож, нөхцөл байдалд ухаалгаар хандах чадвартай байдаг.
2. Өөрийгөө хянах, зохицуулах - Self-regulation Сэтгэл хөдлөлөө хянах, сөрөг сэтгэл хөдлөлийг удирдах чадвар нь хувь хүний амжилтанд чухал үүрэгтэй. Даниэл Гоулман энэ чадварыг хөгжүүлсэн хүмүүс уур бухимдал, айдас зэрэг сэтгэл хөдлөлийг сөрөг нөлөө үзүүлэхээс нь өмнө хянаж чаддаг гэж үзсэн. Энэ нь ялангуяа удирдах албан тушаалтнуудад зайлшгүй шаардлагатай ур чадвар юм.
3. Сэдэлжүүлэлт - Motivation Даниэл Гоулман сэтгэл хөдлөлийн оюун ухааны нэг гол хүчин зүйл болох дотоод урам зориг, сэдэлийг онцолсон байна. Өндөр EQ-тэй хүмүүс зөвхөн гадаад урамшуулал найдах бус, өөрийн дотоод сэдлийг ойлгож, зорилгодоо хүрэх эрмэлзэлтэй байдаг. Тэд аливаа сорилтыг даван туулахдаа илүү тэсвэр тэвчээртэй байна гэж үзсэн.
4. Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох - Empathy Бусдын мэдрэмжийг ойлгох, тэдний нөхцөл байдалд дасан зохицох чадвар юм. Даниэл Гоулманы судалгаанд өндөр EQ-тэй хүмүүс бусдын хэрэгцээ, мэдрэмжийг ойлгох замаар харилцаагаа илүү сайжруулж, илүү үр дүнтэй баг бүрдүүлдэг болохыг харуулсан.
5. Нийгмийн ур чадвар (Social skills) Даниэл Гоулман харилцааны өндөр ур чадвартай хүмүүс илүү амжилттай байгааг судалгаагаар баталсан. Тэд бусадтай үр дүнтэй харилцаж, асуудлыг зөвөөр шийдвэрлэх чадвартай байдаг. Ялангуяа удирдах албан тушаалтнууд багийн ажлыг уялдуулах, хамт олныг зөв удирдах чадвартай байх нь байгууллагын амжилтад ихээхэн нөлөөлдөг.

Даниэл Гоулман сэтгэл хөдлөлийн оюун ухааныг оюун ухааны коэффициентой харьцуулан судалсан бөгөөд IQ нь хүний логик сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварыг хэмждэг бол EQ нь бусадтай харилцах, өөрийгөө удирдах чадварыг тодорхойлдог бөгөөд өндөр IQ-тай хүмүүс ч гэсэн сул EQ-тэй бол ажлын байран дээр амжилт олох магадлал багатайг онцолсон. Судалгаанаас харахад ажлын амжилтын 80% нь EQ-ээс, харин зөвхөн 20% нь IQ-ээс хамаардаг болохыг тогтоожээ.



Зураг 1. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны эрдэмтэдийн тодорхойлолт

Schutte, Malouff, Hall болон бусад судлаачид 1998 онд "Development and Validation of a Measure of Emotional Intelligence" бүтээлдээ сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хэмжих шинэ аргачлал боловсруулж, тэрхүү аргын найдвартай байдал болон баталгаат байдалыг судалсан. Тэдний судалгаа нь Salovey & Mayer нарын 1990 онд боловсруулсан сэтгэл хөдлөлийн оюун ухааны загварт тулгуурласан бөгөөд түүнийг хэмжих Schutte Self-Report Emotional Intelligence Test болох 33 асуулт бүхий тестийг бүтээж, баталгаажуулсан байна. Энэхүү судалгааны гол зорилго сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хэмжих үр дүнтэй арга хэрэгсэл боловсруулахын тулд судлаачид дараах зорилтуудыг дэвшүүлсэн: Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг үнэлэх баталгаатай тест боловсруулах, тестийн найдвартай байдал (reliability) болон хүчин төгөлдөр байдлыг (validity) тогтоох байсан. Сэтгэл хөдлөлийн оюун ухаан хувь хүний зан төлөв болон бусад сэтгэл зүйн хүчин зүйлүүдтэй хэрхэн хамааралтайг судласан. Судалгаанд 337 оролцогч хамрагдсан бөгөөд тэднээс өөрсдийн сэтгэл хөдлөлийн оюун ухааныг үнэлэх 33 асуулт бүхий өөрийгөө үнэлэх тест бөглүүлэх замаар мэдээлэл цуглуулсан. Судлаачид энэхүү тестийн хүчин төгөлдөр байдлыг тогтоохын тулд: Дотоод тохирлын шинжилгээ, дахин тестлэх аргаар найдвартай байдлыг шалгасан байна. Тус аргын найдвартай байдлыг үнэлж Cronbach's alpha = 0.90 байгаа нь найдвартай байдал өндөр байна гэсэн үр дүн гарсан.

Судлаач Д.Энхжаргал "Монголчуудын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан ба уламжлалт харилцааны соёл" өгүүлэлдээ Монголчуудын сэтгэл хөдлөлийн оюун ухаан (Emotional Intelligence, EQ)-ы онцлог, уламжлалт харилцааны соёлтой хэрхэн уялддаг талаар судалсан. Судалгааны зорилго нь Монголчуудын сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, сэтгэл хөдлөлийг удирдах чадвар, бусадтай харилцах харилцааны арга барилд EQ хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох байсан. Судалаач судалгаандаа чанарын болон тоон судалгааны хосолсон арга зүй ашигласан. 500 гаруй оролцогчийн дунд EQ түвшинг тодорхойлох судалгаа хийгдсэн. Судалгааны үр дүнгээс харахад Монголчуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны онцлог нь сэтгэл хөдлөлөө ил тод илэрхийлэхээс зайлсхийх хандлагатай, харилцааны ёс зүй, хүндлэлд суурилсан хандлагатай, нийтийн эрх ашгийг хувийн сонирхлоос дээгүүр тавих соёлтой, зан үйлийн уян хатан байдал (flexibility) өндөртэй байна. Монголчуудын харилцааны онцлог нь сэтгэл хөдлөлийн хяналт, тэвчээртэй байдал, харилцан ойлголцлыг эрхэмлэх чиглэлтэй болохыг судлаач тодорхойлсон. Уламжлалт соёл ба EQ-ийн хамаарлыг авч үзвэл

Монголчуудын уламжлалт харилцааны соёл нь сэтгэл хөдлөлийн оюун ухааныг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг гэж үзэж байна. Ахмад настанаа хүндэтгэх, тэдний сэтгэл санааг ойлгох, бусдыг ойлгож хүндэтгэх, өөрийгөө хянах, тэвчээртэй байх зэрэг сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны түвшин аймаг, хөдөө орон нутгийн иргэдийнх хот суурин газрын хүмүүсээс ялгаатай байна. Хөдөө орон нутгийн иргэд илүү уян хатан, сэтгэл хөдлөлөө илүү хянадаг, хотын иргэд сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ илүү нээлттэй байна. Монголчуудын харилцаа шууд бус, далд утгатай байх нь элбэг, сэтгэл хөдлөлөө хэт илэрхийлэх нь зохимжгүй гэж үзэх хандлагатай, "Үг даах" чадвар чухалд тооцогддог, зөрчилдөөнийг ил тод шийдвэрлэхээс илүү эвийг сахих хандлага өндөртэй, шууд сөргөлдөхөөс илүүтэй намжаах, төвийг сахих, сэтгэл хөдлөлөө хянах, өөрийгөө барих чадвар өндөр, "Ухаантай хүн уурлахаас өмнө боддог" Ухаан дутсан газар уур ноёлдог гэх хандлага нь бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, уур бухимдлыг намжаахад чухал нөлөөтэй байна.

Судлаач О. Гантулга нарын 2009 онд хийгдсэн судалгаанд удирдагчийн EQ өндөр байх нь байгууллагын үр ашиг, бүтээмж, ажилчдын сэтгэл ханамжид эерэг нөлөөтэй болохыг тогтоосон. Түүний судалгаанд хамрагдсан байгууллагуудад EQ хөгжүүлэх сургалт явуулсны дараа ажлын бүтээмж 15%-иар өссөн байна.

Судлаач Б.Энхбаяр, П. Цэрэндондов нарын судалгаанд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан (СХОУ) нь бие даасан сэтгэцийн үзэгдэл болох онолыг судалж оюун ухааны бүрэлдэхүүн хэсэг, танин мэдэхүйн бус чадваруудын нэгдэл, нийгмийн оюун ухааны нэг тал гэх мэт олон талаас тайлбарласан. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь бие даасан, өргөн хүрээтэй, олон талт сэтгэцийн үзэгдэл бөгөөд тархины мэдрэлийн бүтцийн хувьд ухамсарт тархины үйл ажиллагаанаас ангид, тархины бусад хэсгүүдэд хүчтэй нөлөө үзүүлдэг томоохон бүтэцтэй болохыг онолын үүднээс баталсан.

Мөн судлаач Г.Энхжаргалангийн "Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судлах TEI-SF тестийн сэтгэц хэмжил зүйн асуудал" сэдэвт судалгааны бүтээлдээ TEI-SF (Trait Emotional Intelligence Short Form) тестийг монгол хэлээр хөрвүүлж, сэтгэц хэмжил зүйн үнэлгээг хийсэн. Судалгааны дүнгээр тус тестийн дотоод найдвартай байдал (Cronbach's alpha) хангалттай өндөр гарсан. TEI-SF тестийн хүчин төгөлдөр байдлыг шалгахад, хувь хүний зан төлөвийн зарим хүчин зүйлүүд (экстраверси, нээлттэй байдал, ухамсарт байдал, нийцтэй байдал) болон амьдралын сэтгэл ханамжтай эерэг хамааралтай байсан. Харин невротизм болон түгшүүртэй сөрөг хамааралтай гарсан. Монгол хүмүүст тохиромжтой бөгөөд соёлын ялгаатай байдалд бага зэрэг өөрчлөлт орсон боловч ерөнхийдөө олон улсад ашиглагддаг анхны хувилбартай тохирч байв. TEI-SF тестийг Монголд ашиглах боломжтой гэж дүгнэсэн бөгөөд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хэмжихэд үр дүнтэй гэж үзсэн. Судалгааны дүн нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүний зан төлөв, амьдралын сэтгэл ханамжтай өндөр хамааралтай болохыг харуулж байна. Цаашид TEI-SF тестийн илүү өргөн цар хүрээтэй баталгаажуулалт хийх шаардлагатай гэж үзсэн.

Дүгнэлт: Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хувь хүн өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таних, өөрийнхөө сэтгэл хөдлөлийг удирдах, бусдын болон өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох, бусадтай харилцах харилцаандаа оновчтой ашиглах нэгдмэл чадвар бөгөөд хүний нийгмийн дасан зохицол, боловсрол, манлайлал болон амжилтын түвшинд хүчтэй нөлөө үзүүлдэг болох нь олон улсын болон дотоодын судалгаанаас харагдаж байна. Salovey, Mayer, Goleman, Bar-On зэрэг эрдэмтдийн загварууд СХОУ-ны онол, түвшинг тодорхойлох, хэрэглээнд чухал хувь нэмэр оруулсан бөгөөд Монголын судлаачдын бүтээлд СХОУ-ыг уламжлалт харилцааны соёл, зан төлөв, байгууллагын удирдлагатай холбон тайлбарласан нь

онцлог юм. Судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэхэд, СХОУ өндөр байх нь стрессийг даван туулах, бусдыг ойлгох, удирдах, ажил, амьдралын бүтээмжийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлж, боловсрол болон байгууллагын хөгжилд бодит хувь нэмэр оруулж байгааг илэрхийлсэн байна. Цаашид Монголын соёл, зан төлөвийн онцлогт суурилсан хэмжилт, хөгжүүлэх арга зүйг боловсруулж бодит хэрэглээнд нэвтрүүлэх, боловсрол, хүний нөөц, эрүүл мэндийн салбарт EQ хөгжүүлэх хөтөлбөр, сургалтын загвар боловсруулах нь хэрэгцээ шаардлага байсаар байна.

Ашигласан материалын жагсаалт

- Bar-On, R. (2006). The Bar-On model of emotional-social intelligence (ESI). *Psicothema*, 18, 13–25.
- Brackett, M. A., Rivers, S. E., & Salovey, P. (2011). Emotional intelligence: Implications for personal, social, academic, and workplace success. *Social and Personality Psychology Compass*, 5(1), 88–103. <https://doi.org/10.1111/j.1751-9004.2010.00334.x>
- Cherniss, C. (2010). Emotional intelligence: Toward clarification of a concept. *Industrial and Organizational Psychology*, 3(2), 110–126. <https://doi.org/10.1111/j.1754-9434.2010.01231.x>
- Goleman, D. (1995). *Emotional intelligence: Why it can matter more than IQ*. Bantam Books.
- Goleman, D., Boyatzis, R., & McKee, A. (2013). *Primal leadership: Unleashing the power of emotional intelligence*. Harvard Business Review Press.
- Mayer, J. D., Caruso, D. R., & Salovey, P. (2016). The ability model of emotional intelligence. *American Psychologist*, 71(6), 507–517. <https://doi.org/10.1037/a0039905>
- Salovey, P., & Mayer, J. D. (1990). Emotional intelligence. *Imagination, Cognition, and Personality*, 9(3), 185–211. <https://doi.org/10.2190/DUGG-P24E-52WK-6CDG>
- Schutte, N. S., Malouff, J. M., Hall, L. E., et al. (1998). Development and validation of a measure of emotional intelligence. *Personality and Individual Differences*, 25(2), 167–177. [https://doi.org/10.1016/S0191-8869\(98\)00001-4](https://doi.org/10.1016/S0191-8869(98)00001-4)
- Zeidner, M., Matthews, G., & Roberts, R. D. (2004). Emotional intelligence in the workplace. *Applied Psychology*, 53(3), 371–399. <https://doi.org/10.1111/j.1464-0597.2004.00176.x>
- Батсайхан, Б. (2020). Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан ба боловсрол: Монголын туршлага. *Боловсрол судлалын сэтгүүл*, 8(3), 23–38.
- Гантулга, О. (2019). Байгууллагын манлайлал ба сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан. *Менежментийн судалгааны тойм*, 5(1), 75–90.
- Энхжаргал, Д. (2018). Монголчуудын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан ба уламжлалт харилцааны соёл. *Монголын сэтгэл судлалын сэтгүүл*, 6(2), 45–60.
- Энхбаяр, Б., & Цэрэндондов, П. (2020). Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь бие даасан сэтгэцийн үзэгдэл болох нь. *Боловсрол судлал*, 161(3).
- Энхжаргалан, Г. (2019). Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судлах TEI-SF тестийн сэтгэц хэмжил зүйн асуудал. *Боловсрол судлалын сэтгүүл*, 6(2), 45–60. <https://bolovsrolsudlal.mn/index.php/home/article/view/109>
- Энхбаяр, Б., & Цэрэндондов, П. (2020). Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь бие даасан сэтгэцийн үзэгдэл болох нь. *Боловсрол судлал*, 161(3).